



## Татварын талаарх илэн далангүй яриа




### Нэмэгдсэн өртгийн албан татвар Монголд

<p><b>НӨАТ гэж юу вэ?</b></p>	<p>Бараа, үйлчилгээний хэрэглээнд ногдуулах татварыг НӨАТ гэнэ. Барааны хувьд НӨАТ-ыг үйлдвэрлэлийн шат дамжлага бүрт ногдуулж, төлж байдаг. Үүнд түүхий эд, материал худалдан авах, түүнийг боловсруулах, бэлэн бүтээгдэхүүнийг бөөний үнээр нийлүүлэх, жижиглэнгийн худалдаа зэрэг үйл ажиллагааг дурдаж болох юм. Үйлдвэрлэлийн эдгээр шат дамжлага бүр бэлэн бүтээгдэхүүний “өртгийг нэмдэг” тул уг татварыг НӨАТ гэж нэрлэдэг. Үйлчилгээний хувьд НӨАТ-ыг уг үйлчилгээ эцсийн хэрэглэгчид хүрэх үед ногдуулдаг. Үүний үр дүнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэд бүгд худалдан авч буй бүтээгдэхүүндээ татвар төлдөг.</p> <p>Түүхий эд материал, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, бэлэн бүтээгдэхүүн худалдан авах бүрдээ үйлдвэрлэгч, бөөний худалдаа эрхлэгч талууд НӨАТ төлдөг. Эдгээр талууд өөрийн хагас болон бэлэн боловсруулсан бүтээгдэхүүнээ худалдах үед худалдан авагчаас НӨАТ-ыг цуглуулна. Уг татварын төсөвт төлөгдөх хэсэг нь худалдан авагчаас цуглуулсан татвар, бэлтгэн нийлүүлэгчид төлсөн татварын зөрүү байдаг. Үүний үр дүнд аж ахуйн нэгж бүр өөрийн нэмсэн өртөгт НӨАТ-ыг төлдөг. Дор дурдсан жишээгээр үүнийг тайлбарлаж болно.</p> <p>НӨАТ-ын тооцоо нь ярвигтай, цаг зарсан үйл ажиллагаа байдаг тул зөвхөн томоохон аж ахуйн нэгж, байгууллага үүнийг төлдөг. Тиймээс жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь 10 сая төгрөгөөс дээш аж ахуйн нэгжүүд үүнд хамаарна. Түүнээс бага орлоготой аж ахуйн нэгжүүд татвараас чөлөөлөгддөг бөгөөд НӨАТ-ыг хэрэглэгчдээс цуглуулах шаардлагагүй юм.</p> <p>Аж ахуйн нэгжийн хэмжээнээс үл хамааран НӨАТ-ын хувь, хэмжээ нэг шатлалтай буюу 15 хувь байдаг. Үүгээрээ аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвараас мөн ялгаатай юм. Зарим хэрэглэгч, үйлдвэрлэгч талуудыг дэмжсэн заалт, хөнгөлөлтүүд НӨАТ-ын хуульд бусад улс, орнуудтай адилаар тусгалаа олсон байдаг.</p>																												
<p><b>НӨАТ-ын орлого, хувь хэмжээ</b></p>	<p style="text-align: center;"><b>Улсын төсөвт НӨАТ-аас орох жилийн орлого (сая төгрөгөөр)</b></p> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th rowspan="2">НӨАТ-ын орлого</th> <th rowspan="2">Нийт орлогод эзлэх хувь</th> <th colspan="2">2004 онд төлсөн</th> <th colspan="2">НӨАТ-ын орлогод эзлэх хувь</th> </tr> <tr> <th>Хил дээр</th> <th>Хил дотор</th> <th>Хил дээр</th> <th>Хил дотор</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>179.4 Тэрбум</td> <td>26%</td> <td>133.7 Тэрбум</td> <td>45.7 Тэрбум</td> <td>75%</td> <td>25%</td> </tr> </tbody> </table> <p>Монголын хэрэглээний барааны ихэнх хувь нь импортын бараа байдаг тул НӨАТ-ын ихэнх хэсгийг хил дээр төлдөг. Дээрх нийт орлогод эзлэх хувийг 2004 оны төсвийн нийт орлого болох 686,689 сая төгрөгөөс тооцов.</p> <p style="text-align: center;"><b>НӨАТ-ын хэмжээ бусад улс, орнуудад</b></p> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th>Улс орнууд</th> <th>Герман</th> <th>Хятад</th> <th>Норвеги</th> <th>Сингапур</th> <th>БНСУ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Хувь</td> <td>16%</td> <td>17%</td> <td>25%</td> <td>5%</td> <td>10%</td> </tr> </tbody> </table>	НӨАТ-ын орлого	Нийт орлогод эзлэх хувь	2004 онд төлсөн		НӨАТ-ын орлогод эзлэх хувь		Хил дээр	Хил дотор	Хил дээр	Хил дотор	179.4 Тэрбум	26%	133.7 Тэрбум	45.7 Тэрбум	75%	25%	Улс орнууд	Герман	Хятад	Норвеги	Сингапур	БНСУ	Хувь	16%	17%	25%	5%	10%
НӨАТ-ын орлого	Нийт орлогод эзлэх хувь			2004 онд төлсөн		НӨАТ-ын орлогод эзлэх хувь																							
		Хил дээр	Хил дотор	Хил дээр	Хил дотор																								
179.4 Тэрбум	26%	133.7 Тэрбум	45.7 Тэрбум	75%	25%																								
Улс орнууд	Герман	Хятад	Норвеги	Сингапур	БНСУ																								
Хувь	16%	17%	25%	5%	10%																								

**НӨАТ-ын орлого юунаас бүрддэг вэ?**

НӨАТ-ын орлогын тал хувь нь шатахуунаас, 19 хувь нь жижиглэнгийн худалдаанаас, 13 хувь нь харилцаа холбооноос, 10 хувь нь цахилгаан дулааны борлуулалтаас, 8 хувь нь зоогийн газрын үйлчилгээнээс ордог.



**НӨАТ-ыг хэрхэн тооцож, төлдөг вэ?**

1. Үйлдвэрлэгч 1000 төгрөгийн өртөгтэй түүхий эд, материал худалдан авсан. НӨАТ-ын 15 хувийг тооцон уг үйлдвэрлэгч 1150 төгрөгийг бэлтгэн нийлүүлэгчид төлнө. Бэлтгэн нийлүүлэгч улсын төсөвт 150 төгрөгийг төлөх юм.
2. Үйлдвэрлэгч түүхий эд материал, хөдөлмөр, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал гарган үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ бөөний худалдаа эрхлэгчид 4000 төгрөгөөр борлуулсан. Бөөний худалдаа эрхлэгч үйлдвэрлэгч талд 15 хувийн НӨАТ-ыг тооцон 4600 төгрөгийг төлнө.
3. Бөөний худалдаа эрхлэгч уг бүтээгдэхүүнийг жижиглэнгийн худалдаа эрхлэгчид 6000 төгрөгөөр зарсан бөгөөд НӨАТ-ыг тооцон 6900 төгрөг хүлээн авсан.
4. Жижиглэнгийн худалдаа эрхлэгч эцсийн үйлчлүүлэгчээс НӨАТ тооцсон дүн болох 9600 төгрөг (8000 төгрөг нэмэх нь 1600)-ийг нэхэмжилнэ. Бүх бэлтгэн нийлүүлэгчээс төлөх татварын дүн 1600 төгрөгийг төсвийн орлогод тооцно. Жижиглэнгийн худалдаа эрхлэгч болон бусад бэлтгэн нийлүүлэгч өөрийн төлсөн татварын хасалтыг хийж нийт 1600 төгрөгийн татварыг уг бүтээгдэхүүнээс улсын төсөвт төлнө.
5. Улсын төсөв 150 төгрөгийг түүхий эд материалын бэлтгэн нийлүүлэгчээс, 450 төгрөг (600-150)-ийг үйлдвэрлэгчээс, 300 төгрөг (900-600)-ийг бөөний худалдаа эрхлэгчээс, 700 төгрөг (1600-900)-ийг жижиглэнгийн худалдаа эрхлэгчээс тус тус татварын төлбөр болгон хүлээн авна. Эдгээр НӨАТ-ын төлбөрүүдийн нийлбэр нь 1600 төгрөг буюу эцсийн хэрэглэгчийн төлсөн 8000 төгрөгийн 15 хувь юм.

Энэхүү мэдээлэл нь татварын шинэчлэлийн талаар нийт ард иргэдийн санаа бодлыг сонсох зорилгоор Сангийн яам, Үндэсний Татварын Ерөнхий Газраас явуулах “Татварын илэн далангүй яриа” сэдэвт цуврал хэлэлцүүлгийн тавдугаар хэсэг юм. Та бүхэн татварын шинэчлэлийн хуулийн төслийн англи, монгол хувилбарыг “Нээлттэй засаг” вэб сайт ([www.open-government.mn](http://www.open-government.mn)), Сангийн яамны вэб сайт ([www.mof.pmis.gov.mn](http://www.mof.pmis.gov.mn)), ҮТЕГ-ын вэб сайт ([www.mta.mn](http://www.mta.mn)) - аас үзэж, саналаа ирүүлж болно.